

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ОЛОН НИЙТЭЭР
ХЭЛЭЛЦҮҮЛСЭН БАЙДАЛ**

№	Хуулийн төсөл хэлэлцүүлсэн байдал	Он сар өдөр	Гарсан санал
1	Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан	2023.07.28-ны өдөр	Гарсан шийдвэр: <ul style="list-style-type: none"> • Хуулийн төслийг бүтээгдэхүүний амьдралын мөчлөгөөр боловсруулах; • Газар, хэлтсийн дарга нар 2023.08.04-ний өдөр багтаан санал өгөх
2	Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан	2023.09.20-ны өдөр	Гарсан шийдвэр, санал: <ol style="list-style-type: none"> 1. Хуулийн төслийг бүтээгдэхүүнээр салгасан байдлаар боловсруулах 2. Дараах саналыг тусгах: <ul style="list-style-type: none"> ▪ Нөхцөлт зөвшөөрлийн асуудлыг тодорхой болгох; ▪ Эмийн чанарыг хяналтын тогтолцоог сайжруулах; ▪ Өмнөх хуулийн гол зохицуулалтыг эргэж харах; ▪ Зарим нэр томъёоны тодорхойлолтыг нэмж оруулах; ▪ Зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлэх; ▪ Эмийн зөвлөлийг хэвээр үлдээх; ▪ Стандарт, техникийн зохицуулалт хэвээр үлдээх; ▪ Худалдан авах нэгж хаана байхыг дахин ярилцах; ▪ Эмнэлзүйн туршилт судалгаан дээр АУЕЗХХ-ноос албан ёсоор санал авах; ▪ Салбар зөвлөл болон мэргэжлийн хүмүүсийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах; ▪ Мэргэжлийн хувьд хэлэлцүүлгээ зохион байгуулж, асуудлыг эцэслэсний дараа хуульчдын саналыг авах; ▪ Эмийн зохицуулалт, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалт, биологийн идэвхт бүтээгдэхүүний зохицуулалт тус бүрээр салгаж хуулийн төсөл боловсруулах.
3	Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан	2023.11.02-ны өдөр	Гарсан шийдвэр, санал: <ul style="list-style-type: none"> • Хуулийн төсөлд туссан нэр томъёоны тодорхойлолтыг дахин харах; • Хуулийн төслийн 6.8-д “Эмийн сангийн тусгай зөвшөөрлийг үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага болон түүнд хувь эзэмшигч хуулийн этгээдэд олгохгүй.” гэснийг хасах

			<ul style="list-style-type: none">• Хуулийн төслийн 3.1.2-д “биобэлдмэл” гэж тусдаа тусгасныг эм дотор оруулах нь зүйтэй.• Ариутгал, халдваргүйтгэлийн бодистой холбоотой Эрүүл мэндийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд зохицуулалтууд байгаа тул эдгээр хуулийн хүрээнд зохицуулах нь зүйтэй• Салбарын нэгдсэн хяналтыг задлан, салгаж, чиглэл чиглэлээр ерөнхий байцаагч гаргах нь буруу гэж үзэж байна. Бодлогын хувьд нэгдсэн байх хэрэгтэй тул хуулийн төсөлд туссан эм, эмнэлгийн хэрэгслийн ерөнхий байцаагч гэснийг хасах хэрэгтэй байна;• Хуулийн төслийн “эмнэлзүйн судалгаа” гэдэг дээр “Trail” гэдэг утгыг заавал оруулмаар байна. Эмнэлзүйн туршилт судалгаа гэхээр болгоомжилж байвал одоогийн хуульд байгаа “сорилт судалгаа” гэдгээр оруулдаг.• Хуулийн төслийн 53.2 дахь заалт Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.4, 10.6 дахь заалтыг зөрчиж байгаа тул эргэж харах;• Шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалтад тэнцээгүй эмнэлгийн тоног төхөөрөмжийг хэрхэн зохицуулах талаар тусгах нь зүйтэй байна.• Хуулийн төсөлд туссан нөхцөлт зөвшөөрөл; яаралтай горимоор олгох зөвшөөрөл гэснийг нэгтгэх;• “Эмийн сангийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвхөн эм барих эрхтэй эм зүйч байна” гэж нэмэх• “Эмийн сангаар худалдах эмийн үнэ эм ханган нийлүүлэх байгууллагаас тогтоосон үнээс 25 -30 хувь, эм ханган нийлүүлэх байгууллагаас тогтоох эмийн үнэ нь суурь үнээс 10-15 хувиас хэтрүүлэхгүйгээр нэмж тооцсон байна.” гэж нэмэх• Хуулийн төсөлд туссан багийн эмч гэснийг эргэж харах. Эрүүл мэндийн тухай хуульд энэ тодорхойлолт байдаггүй.• Хуулийн төслийн хэд хэдэн заалтад нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актыг агентлагийн дарга батлахаар байна. Энэ нь салбарын сайдын эрх мэдэлд халдсан эсэхийг нягтлах нь зүйтэй байна.• Хуулийн төсөлд эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж дээр туссан зохицуулалт нь ахисан түвшний зохицуулалт байна. Манай Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын өнөөдрийн чадавхтай нийцэх эсэхээ бодолцох нь зүйтэй байна.
--	--	--	---

			<ul style="list-style-type: none"> • Эмийн худалдан авалтад ерөнхий гэрээний худалдан авалтыг баримтална гэж тусгах • Эм импортлогч нь зөвхөн өөрийн импортолсон эмийг эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагад бөөний үнээр түгээнэ. Эм ханган нийлүүлэх байгууллагууд нь өөр хоорондоо эм солилцохыг хориглоно • Эмнэлгийн мэргэжилтэн эм, эмнэлгийн хэрэгслийг сурталчлах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээхийг хориглоно • Эм ханган нийлүүлэх байгууллага нь эмийн сан, эрүүл мэндийн байгууллагуудад тэгш, ялгаваргүй хандаж, ижил бүтээгдэхүүн, үнээр үйлчилнэ
4	“Эмийн чанар, аюулгүй байдал, худалдан авах ажиллагааг боловсронгуй болгох асуудал” сэдэвт семинар	2023.06.02-ны өдөр	<p>Оролцогч:</p> <ul style="list-style-type: none"> - ЭМЯам; - ЭЭХХЗГазар; - Эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл; - Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл; - АХБ-ны МОН-6652 Эмийн аюулгүй байдал, халдварт бус өвчний хяналтыг сайжруулах нь төсөл; <p>Гарсан санал:</p> <ul style="list-style-type: none"> - Худалдан авалтыг сайжруулах, ерөнхий гэрээний худалдан авалтын нэр төрлийг нэмэгдүүлэх; - Зохицуулалтын байгууллагыг чадавхжуулах; - Чанарын хяналтын лабораторийг бэхжүүлэх;
5	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол улс дахь Суурин төлөөлөгчтэй уулзаж, санал солилцсон.	2023.09.13-ны өдөр	<p>Гарсан санал:</p> <ul style="list-style-type: none"> - Бүтээгдэхүүн тус бүрээр зохицуулалтыг салгах; - Эмийн зах зээлийг чөлөөт өрсөлдөөний байдлаар зохицуулах, үнийн ил тод байдлыг хангах; - Нэр томьёоны хэсгийг дахин эргэж харах - Зарчмын хувьд анхаарах хэсгүүдээ сайн ярилцах
6	Мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүдэд танилцуулж, санал авсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> ▪ АУ-ны ёс зүйн хяналтын хороо 	2023.10.10-ны өдөр	<p>Гарсан санал: Дараах хэсгийг дахин найруулах</p> <ul style="list-style-type: none"> - Үнийн зохицуулалт хэсгийг дэлгэрүүлэх - Зарим төрийн байгууллагын чиг үүргийг тусгах - Биологийн идэвхт бүтээгдэхүүний зохицуулалтыг зарчмын хувьд тохирох

	<ul style="list-style-type: none"> ▪ Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөл ▪ Эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн мэргэжлийн салбар зөвлөл ▪ Эм зүй, эм судлалын мэргэжлийн салбар зөвлөл 		<ul style="list-style-type: none"> - Туршилт судалгаа хэсгийг гишүүд дахин найруулж өгөх - Зөвлөл, хороодын чиг үүргийг тусгах
7	<p>Мэргэжлийн салбар зөвлөл, Холбоод, ЭМБ, Салбарын эрдэмтийг оролцуулсан 2 өдрийн вакуумжсан хэлэлцүүлэг хийж, гарсан саналыг тусгасан.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар ▪ АУ-ны ёс зүйн хяналтын хороо ▪ Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөл ▪ Эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн мэргэжлийн салбар зөвлөл ▪ Эм зүй, эм судлалын мэргэжлийн салбар зөвлөл ▪ Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний төлөөлөл ▪ Эрүүл мэндийн байгууллага төлөөлөл ▪ Эрүүл мэндийн яаманд ажиллаж буй мэргэжлийн хүмүүс 	2023.10.12-13-ны өдөр	<p>Гарсан үр дүн:</p> <p>Хуулийн төслийн бүтээгдэхүүний зохицуулалтын бүлгүүд болох дараах бүлгүүд дээр багаар хуваагдаж, ажилласан. /2023.10.12-ны өдөр/</p> <ul style="list-style-type: none"> ▪ Дөрөвдүгээр бүлэг. Эм, биобэлдмэл ▪ Тавдугаар бүлэг. Эмнэлгийн хэрэгсэл ▪ Зургаадугаар бүлэг. Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн <p>Хуулийн төслийн харилцааны зохицуулалтын бүлгүүд болох дараах бүлгүүд дээр хэлэлцүүлэг хийж, гарсан саналыг тусгасан /2023.10.13-ны өдрийн үдээс өмнө/</p> <ul style="list-style-type: none"> ▪ Гуравдугаар бүлэг. Тусгай зөвшөөрөл, хангамжийн байгууллагад тавигдах шаардлага ▪ Долдугаар бүлэг. Эм, Биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн импорт, экспорт ▪ Наймдугаар бүлэг. Эм, Биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн үнийн зохицуулалт <p>Хуулийн төслийн дараах бүлгүүд дээр хэлэлцүүлэг хийж, гарсан саналыг тусгасан /2023.10.13-ны өдрийн үдээс хойш/</p> <ul style="list-style-type: none"> ▪ Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл, ▪ Хоёрдугаар бүлэг. Эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн талаар төрөөс баримтлах бодлого ▪ Есдүгээр бүлэг. Зохицуулалтын тогтолцоо, ▪ Аравдугаар бүлэг. Мэргэжлийн хяналт, бүрэн эрх ▪ Арван нэгдүгээр бүлэг. Бусад

8	Мэргэжлийн салбар зөвлөлүүдээс албан бичгээр санал авсан байдал.	2023 он	<ul style="list-style-type: none"> - Эм зүй, эм судлалын мэргэжлийн салбар зөвлөл /2023.09.29 -ны өдрийн 2023/05 тоот албан бичиг/ - Эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн мэргэжлийн салбар зөвлөл /2023.10.12-ны өдөр хэлэлцүүлгийн үед/ - Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөл /2023.10.12-ны өдөр хэлэлцүүлгийн үед/
---	--	---------	---

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авч байна.

📅 2024-01-20 09:21:00 / 🗨️

A- A A+

ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ АВЧ БАЙНА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт заасны дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авч байна. Хуулийн төсөлтэй танилцаж, саналаа 2024 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн дотор Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газарт албан бичгээр, эсхүл tuvshinbayar@moh.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Эрүүл мэндийн яамны цахим хуудаст Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан дараах баримт бичгийг байршуулсан болно. Үүнд:

- 1.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал;
- 2.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- 3.Хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүд;
- 4.Эм, эмнэлгийн хэрэгслийн шинэчилсэн найруулгын төслийн товч танилцуулга;
- 5.Эм, эмнэлгийн хэрэгслийн шинэчилсэн найруулгын төслийн дэлгэрэнгүй танилцуулга;
- 6.Эм, эмнэлгийн хэрэгслийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээ;
- 7.Эм, эмнэлгийн хэрэгслийн шинэчилсэн найруулгын төслийн зардалын тооцоо
- 8.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хэрэгжилт /эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, биологийн идэвхт бүтээгдэхүүн, уламжлалт эм, эмийн үнэ, чанар/-ийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангууд;

Хэрэгжилт үр дагавар үнэлгээ 1 хэсэг
Хэрэгжилт үр дагавар үнэлгээ 2 хэсэг
Хэрэгжилт үр дагавар үнэлгээ 3 хэсэг
Хэрэгжилт үр дагавар үнэлгээ 4 хэсэг
Хэрэгжилт үр дагавар үнэлгээ 5 хэсэг

Мэдээний ангилал

Цаг үеийн мэдээ

Коронавируст халдвар (COVID-19)-ын үед эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангахад чиглэсэн заавар зөвлөмж

Коронавируст халдвартай холбоотой журам, заавар

Хүлээгдлийн мэдээ

Сошиалд дагаарай